



БАЯНХОНГОР АЙМГИЙН  
ӨЛЗИЙТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 01 сарын 07 өдөр

Дугаар А/04

Улаан-Уул

Бог малын хээлтүүлэгчийг  
ялган суурилах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Малын генетик нөөцийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4.3, 8.4.4, 8.4.5, 8.4.7, Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.12.1, 9 дүгээр зүйлийн 9.8 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Бог малын хээлтүүлэгч маллах малчныг сонгон шалгаруулж, хээлтүүлэгч ялган төвлөрүүлэх, хариуцлагын гэрээ байгуулах ажлыг 2022 оны 01 дүгээр сарын 15-ны өдрөөс 2022 оны 04 дүгээр сарын 15 хугацаанд зохион байгуулахыг багуудын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

2. Бог малын хээлтүүлэгчийн тэжээллэг, арчилгаа, маллагаа, зун намрын нутаг бэлчээрийн хуваарь, гадны аймаг сум, багийн малчдаас хээлтүүлэгч мал авахгүй байх зэрэгт хяналт тавьж, заавар зөвлөмжөөр хангаж хавар, намрын үзлэг ангилалтад бүрэн хамруулж ажиллахыг Хөдөө аж ахуйн тасаг (О.Энхболд)-т, хээлтүүлэгч малын шилжилт, хөдөлгөөн, эрүүл мэндэд байнгын хяналт тавьж, мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээнд технологид хугацаанд бүрэн хамруулж ажиллахыг Мал эмнэлгийн тасаг (О.Намжирмаа)-т тус тус даалгасугай.

3. Мал, амьтны гоц халдварт болон халдварт өвчний гаралт нэмэгдэж байгаатай холбогдуулан мэргэжлийн байгууллага, мэргэжилтний зөвшөөрөлгүйгээр гадны аймаг, сум, багаас хээлтүүлэгч мал авч маллах, худалдан авахыг тус тус хориглосугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч дарга (Г.Баттогтох)-д даалгасугай.

ДАРГА  Т.ЭРДЭНЭБАТ



642101159